

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 65.160

Янжуур тамхи. Техникийн ерөнхий шаардлага	MNS 5024 : 2013
Cigarettes. General technical requirement	MNS 5024 : 2008-ын оронд

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2013 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 17 дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандартын норматив шаардлагыг заавал мөрдөнө.

Энэхүү стандартыг 2014 оны 05 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөнө.

1 ЗОРИЛГО

Энэхүү стандартын зорилго нь янжуур тамхины үйлдвэрлэл, импорт, худалдаанд тавих шаардлагыг тогтоож, тамхины хор хөнөөлөөс хүн амын эрүүл мэндийг хамгаалахад оршино.

2 ХАМРАХ БА ХЭРЭГЛЭХ ХҮРЭЭ

2.1 Янжуур тамхийг үйлдвэрлэх, савлах, шошголох, шалгах, хадгалах, тээвэрлэх, борлуулахад хамаарна.

2.2 Энэхүү стандартыг янжуур тамхийг үйлдвэрлэгч, импортлогч, борлуулагч, хэрэглэгч болон хяналт, баталгаажуулалтын үйл ажиллагаанд мөрдөнө.

3 НОРМАТИВ ИШЛЭЛ

Энэ стандартад ишлэл хийсэн дараах стандарт, баримт бичиг, тэдгээрт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны хэвлэлээс иш татаж хэрэглэнэ.

- MNS ISO 10185: 2012, Тамхи ба тамхин бүтээгдэхүүн – Тайлбар толь
- MNS ISO 10315: 2001, Янжуур тамхи - Утааны конденсат дахь никотины хэмжээг тодорхойлох. Хийн хроматографийн арга
- MNS ISO 8243 : 2011, Янжуур тамхи – Дээж авах
- MNS ISO 3308 : 2001, Лабораторийн тамхи татагч машин–Тодорхойлолт ба стандарт нөхцөл
- MNS ISO 4387 : 2001, Янжуур тамхи – Лабораторийн тамхи татагч машинаар никотингүй нийт хуурай үлдэгдэл бодисын (бохь) хэмжээг тодорхойлох
- MNS 5549 : 2006, Хүнсний бүтээгдэхүүнд афлатоксин В1, В2, G1, G2-ыг тодорхойлох нимгэн үет хроматографийн арга
- MNS 5127 : 2002, Тамхи, тамхин бүтээгдэхүүн. Чийг тодорхойлох. Жингийн арга

MNS 5024:2013

- MNS 5128 : 2002, Тамхи, тамхин бүтээгдэхүүн. Никотин ба бохины хэмжээг тодорхойлох. Жингийн арга
- MNS 5129 : 2002, Тамхи тамхин бүтээгдэхүүн. Хлорорганик пестицид тодорхойлох. Нимгэн үет хроматографийн арга
- MNS 5130 : 2002, Тамхи тамхин бүтээгдэхүүн. Фосфорорганик пестицид тодорхойлох. Нимгэн үет хроматографийн арга
- MNS CAC/RCP 1 : 2003, Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим
- MNS 4244 : 1994, Хөдөлмөр хамгааллын стандартын систем. Галын аюулгүй байдал ерөнхий шаардлага
- MNS 4968 : 2000, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага норм, хэмжих аргад тавигдах ерөнхий шаардлага
- MNS 5364 : 2004 Хүнсний барааны агуулах. Техникийн ерөнхий шаардлага

4 НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү стандартад хэрэглэсэн нэр томьёог MNS ISO 10815 : 2012, Тамхи ба тамхин бүтээгдэхүүн – Тайлбар толь стандартын дагуу ойлгоно.

4.1 ЯНЖУУР ТАМХИ

Тамхины ургамлын навчийг технологийн дагуу боловсруулж зориулалтын цаасаар ороосон, шүүлтүүртэй, татаж хэрэглэх бүтээгдэхүүн.

5 ТЕХНИКИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

5.1 Янжуур тамхийг батлагдсан технологийн заавар, жор, орцын дагуу MNS 4968 : 2000, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага стандартын шаардлага хангасан үйлдвэрт үйлдвэрлэнэ.

5.2 Янжуур тамхийг үйлдвэрлэхэд хэрэглэх түүхий эд, туслах материал нь MNS CAC/RCP 1 : 2003 “Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим” стандартын шаардлага хангасан байна.

5.3 Янжуур тамхи импортлоход чанар, аюулгүй байдлын талаар үйлдвэрлэгч орны эрх бүхий байгууллагуудаас олгосон холбогдох баримт бичгийг бүрдүүлсэн байна.

5.4 Янжуур тамхины физикийн үзүүлэлтүүд нь 1 дүгээр хүснэгтэд үзүүлсэн шаардлагыг хангасан байна.

Янжуур тамхины физикийн үзүүлэлт

1-р хүснэгт

д/д	Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Хэмжээ
1.	Янжуур тамхины нийт урт	мм	(45-160)±0,5
2.	Янжуур тамхины шүүлтүүртэй хэсгийн урт	мм	(13-36)±0,5
3.	Янжуур тамхины тамхитай хэсгийн урт	мм	(45-88)±0,5
4.	Янжуурын тамхины голч	мм	(4-9)±0,2
5.	1 ширхэг янжуурын жин	г/ш	(0,3-1,3)±0,05
6.	Янжуур тамхины чийглэг	%	13±2

5.5 Янжуур тамхины бүрэн бүтэн байдал нь алдагдаагүй, татдаг хэсгийн дагуу жигд дүүргэгдсэн байна.

5.6 Бүслүүр цаасыг янжуур тамхины их биед үрчийлгэж нугалахгүйгээр сайн наасан байна.

5.7 Янжуур тамхины химийн үзүүлэлтийн зөвшөөрөгдөх хэмжээ 2 дугаар хүснэгтэд үзүүлсэн шаардлагыг хангасан байна.

Янжуур тамхины химийн үзүүлэлт

2-р хүснэгт

д/д	Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ
1.	Бохь	мг/ш	14,0
2.	Никотин	мг/ш	1,3
3.	Нүүрстөрөгчийн дутуу исэл	мг/ш	15,0
4.	Афлатоксин В1, В2	-	Байж болохгүй
5.	Пестицид	Хлорорганик	0,1
		Фосфорорганик	0,2
6.	Нийлбэр гамма идэвхжил (хяналтын түвшин)	Бк/г	250,0
7.	Мансууруулах бодис	-	Байж болохгүй

6 ШАЛГАЖ, ХҮЛЭЭН АВАХ

Янжуур тамхины гаднах байдал (Тамхины цаас, хайрцаг)-ыг А хавсралтаар, чанарыг дараах стандартын дагуу шалгаж хүлээн авна. Үүнд:

6.1 MNS 5127 : 2002, Тамхи, тамхин бүтээгдэхүүн. Чийг тодорхойлох. Жингийн арга

6.2 MNS 5128 : 2002, Тамхи, тамхин бүтээгдэхүүн. Никотин ба бохины хэмжээг тодорхойлох. Жингийн арга

MNS 5024:2013

6.3 MNS 5129 : 2002, Тамхи, тамхин бүтээгдэхүүн. Хлорорганик пестицид тодорхойлох. Нимгэн үет хроматографийн арга

6.4 MNS 5130 : 2002, Тамхи тамхин бүтээгдэхүүн. Фосфорорганик пестицид тодорхойлох. Нимгэн үет хроматографийн арга

6.5 MNS ISO 10315 : 2001, Янжуур тамхи - Утааны конденсат дахь никотины хэмжээг тодорхойлох. Хийн хроматографийн арга

6.6 MNS 5549 : 2006, Хүнсний бүтээгдэхүүнд афлатоксин В1, В2, G1, G2-ийг тодорхойлох нимгэн үет хроматографийн арга

6.7 MNS ISO 4387 : 2001, Янжуур тамхи– Лабораторийн тамхи татагч машинаар никотингүй нийт хуурай үлдэгдэл бодисын (бохь) хэмжээг тодорхойлох

7 САВЛАХ, ШОШГОЛОХ

7.1 Янжуур тамхийг 1 хайрцагт 20 ширхэгээс цөөнгүй тоогоор савлана.

7.2 Эрүүл мэндийн зурагт анхааруулга нь тамхи татсан, дам тамхидалтад өртсөнөөс болж хүний эрүүл мэндэд учруулах хор хөнөөлийг дүрсэлсэн зураг, үндсэн болон тайлбар мэдээллээс бүрдэнэ.

7.2.1 Эрүүл мэндийн зурагт анхааруулгыг тамхины хайрцаг, боодлын нүүр болон арын хамгийн том хэмжээтэй хоёр тал дээр хэвлэсэн байна.

7.2.2 Эрүүл мэндийн зурагт анхааруулгыг хайрцаг, боодлыг задлах үед гэмтэхгүй байхаар байрлуулна.

7.2.3 Эрүүл мэндийн анхааруулгыг “В” хавсралт дахь загварын дагуу хийсэн байна.

7.2.4 Үйлдвэрлэж, импортолж байгаа янжуур тамхинд эрүүл мэндийн 6 төрлийн зурагт анхааруулгыг ижил тоогоор хэрэглэсэн байна.

7.2.5 Эрүүл мэндийн зурагт анхааруулга нь тамхины хайрцагны гадаргуугийн доод хэсэгт байрлах ба 50 хувиас доошгүй талбайг эзэлсэн байна.

7.2.6 Эрүүл мэндийн зурагт анхааруулгын зураг нь эх хувьтайгаа адилхан, тусгал сайтай тод харагдахуйц, 4 өнгөтэй байх ба 1 мм-ийн өргөн хар өнгийн хүрээтэй байна.

7.2.7 Эрүүл мэндийн зурагт анхааруулгын бичвэр тус бүрийг дараах байдлаар бичнэ. Үүнд:

- 1 дүгээр зураг: **“Тамхи ГОО САЙХНЫГ гутаана.”** гэсэн бичиглэлийн **“Тамхи...”**, **“...гутаана.”** гэсэн бичиглэлийг компьютерийн **“Arial”**-фондын, **“bold”** хэлбэр, жижиг үсгийн **“12”** хэмжээгээр, **“ГОО САЙХНЫГ”** гэсэн бичиглэлийг **“Arial”**- фондын, **“bold”** хэлбэр, жижиг үсгийн **“16”** хэмжээгээр бичиж, зургийн дээд хэсгийн ирмэг дагуу цагаан дэвсгэр дээр улаанаар бичнэ.

- 2 дугаар зураг: **“Тамхи хорт хавдар үүсгэнэ.”** гэсэн бичиглэлийн **“Тамхи...”**, **“...үүсгэнэ.”** гэсэн бичиглэлийг компьютерийн **“Arial”**-фондын, **“bold”** хэлбэр, жижиг үсгийн **“14”** хэмжээгээр, **“хорт хавдар”** гэсэн бичиглэлийг **“Arial”**-фондын, **“bold”** хэлбэр, жижиг үсгийн **“20”** хэмжээгээр, зургийн дээд хэсгийн ирмэг дагуу шар өнгөөр бичнэ.
- 3 дугаар зураг: **“Тамхи бэлгийн сулрал үүсгэнэ.”** гэсэн бичиглэлийн **“Тамхи...”**, **“...үүсгэнэ.”** гэсэн бичиглэлийг компьютерийн **“Arial”**-фондын, **“bold”** хэлбэр, жижиг үсгийн **“12”** хэмжээгээр, **“бэлгийн сулрал”** гэсэн бичиглэлийг **“Arial”**-фондын, **“bold”** хэлбэр, жижиг үсгийн **“18”** хэмжээгээр, зургийн дээд хэсгийн ирмэг дагуу шар өнгөөр бичнэ.
- 4 дүгээр зураг: **“Тамхи ҮХЖИЛ үүсгэнэ.”** гэсэн бичиглэлийн **“Тамхи...”**, **“...үүсгэнэ.”** гэсэн бичиглэлийг компьютерийн **“Arial”**-фондын, **“bold”** хэлбэр, жижиг үсгийн **“14”** хэмжээгээр, **“ҮХЖИЛ”** гэсэн бичиглэлийг **“Arial”**-фондын, **“bold”** хэлбэр, жижиг үсгийн **“20”** хэмжээгээр, зургийн дээд хэсгийн ирмэг дагуу шар өнгөөр бичнэ.
- 5 дугаар зураг: **“Тамхи - ҮХЛИЙН ХОР мөн.”** гэсэн бичиглэлийн **“Тамхи...”**, **“...мөн.”** гэсэн бичиглэлийг компьютерийн **“Arial”**- фондын, **“bold”** хэлбэр, жижиг үсгийн **“14”** хэмжээгээр, **“ҮХЛИЙН ХОР”** гэсэн бичиглэлийг **“Arial”**-фондын, **“bold”** хэлбэр, жижиг үсгийн **“18”** хэмжээгээр, зургийн дээд хэсгийн ирмэг дагуу шар өнгөөр бичнэ.
- 6 дугаар зураг: **“Тамхи ургийн ГАЖ ХӨГЖИЛ үүсгэнэ.”** бичиглэлийн **“Тамхи ургийн...”**, **“...үүсгэнэ.”** гэсэн бичиглэлийг компьютерийн **“Arial”**-фондын, **“bold”** хэлбэр, жижиг үсгийн **“12”** хэмжээгээр, **“ГАЖ ХӨГЖИЛ”** гэсэн бичиглэлийг **“Arial”**-фондын, **“bold”** хэлбэр, жижиг үсгийн **“18”** хэмжээгээр, зургийн баруун дээд хэсэгт шар өнгөөр бичнэ.

7.2.9 Стандартын “В” хавсралтаар батлагдсан эрүүл мэндийн зурагт анхааруулгын бичвэрийн хэлбэр, хэмжээ, өнгө, загварыг өөрчлөхийг хориглоно.

7.2.10 Эрүүл мэндийн зурагт анхааруулгын эзлэх талбайд өөр ямар нэгэн наалт, бичиглэл, зураг дүрс байрлуулахгүй.

7.2.11 Эрүүл мэндийн зурагт анхааруулгыг хайрцаг дээр “С”, боодол дээр “D”, авдар дээр “E” хавсралтын дагуу тус тус байрлуулна.

7.3 Тамхины хайрцаг, боодлын хажуу гадаргууд дараах мэдээллийг Монгол хэлээр бичсэн байна. Үүнд:

- Үйлдвэрлэгч; импортлогч; экспортлогч улс, байгууллагын нэр;
- Үйлдвэрлэсэн он, сар, өдөр;
- Хадгалах, дуусгавар болох хугацаа
- Тамхины найрлагад агуулагдах хорт бодис /бохь, никотин/-ын хэмжээ;
- Үндэсний стандартын дугаар;

MNS 5024:2013

- “Монгол Улсад худалдаалахыг зөвшөөрөв.” гэсэн тэмдэглэл

ТАЙЛБАР: Үндэсний стандартын дугаарыг зөвхөн дотооддоо үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд тавина.

7.4 Тамхины хайрцаг, боодол дээр тухайн тамхийг бусад тамхинаас илүү хор нөлөө багатай гэсэн утгатай үг бичих буюу түүнтэй адилтгах лого, брэндийн дүрс, тэмдэг, өнгө, тэдгээрийн хослол хэрэглэхийг хориглоно.

7.5 Эрүүл мэндийн анхааруулгын загвар ”В”-Хавсралт-ыг Стандартчиллын төв байгууллагаас CD-ээр авна.

8 ДЭЭЖ АВАХ

MNS ISO 8243 : 2011, Янжуур тамхи – Дээж авах стандартын дагуу дээж авна.

9 ТЭЭВЭРЛЭХ, ХАДГАЛАХ

9.1 Янжуур тамхийг шаардлага хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

9.2 Тамхийг MNS 5364:2011 “Худалдааны агуулах. Ерөнхий шаардлага” стандартын 4.6 дахь заалт “**Төрөлжсөн агуулах**-Хадгалах онцгой нөхцөл (халуун, хүйтэн, агаарын харьцангуй чийг тохируулах гэх мэт) горим шаарддаг тодорхой бүлгийн бараа хадгалах зориулалттай агуулах”-ын шаардлагыг хангасан агуулахад хадгална.

9.3 Хадгалах байр нь 65 ± 5 %-ийн харьцангуй чийглэгтэй байх ба орчны температур нь 17°C -ээс 20°C байна.

9.4 Янжуур тамхийг үйлдвэрлэснээс хойш 2 жил хүртэлх хугацаагаар зориулалтын агуулахад хадгалж болно.

9.5 Авдартай тамхийг шалнаас 10 см, халаагуураас 20 см-ээс багагүй зайд гэрлийн шууд тусгалаас хамгаалсан, сараалж модон тавиур дээр дундуур нь агаар чөлөөтэй орох зайтай байрлуулна.

ТӨГСӨВ.

**А” ХАВСРАЛТ
(мэдээллийн)****ЯНЖУУР ТАМХИНЫ ГАДНАХ БАЙДЛЫГ ҮНЭЛЭХ**

Янжуур тамхины гаднах байдлыг дараах аргаар үнэлнэ. Энэ аргаар тогтоох гэмтэл согогийн оноо 120-иос хэтрэхгүй байна.

А.1. 10 хайрцгийг шинжилгээний дээж болгон авна.

А.2. Янжуур тамхины хайрцагны гадна талын гэмтэл согогийг их, дунд, бага гэсэн 3 төрөлд хувааж үнэлнэ.

А.3. Их гэмтэл, согогт тооцох үзүүлэлт

Хайрцагны гадна тал: зориулалтын бүрхүүлийн бүрэн бүтэн байдал алдагдсан байх; хайрцагны аль нэг талын наалт салсан, тухайн хайрцган дотор өөр нэрийн тамхи байх, тамхины тоо дутах, тамхины ерөнхий хэв байдал алдагдахаар хоорондоо эсвэл хайрцагны дотор цаасанд наалдсан байх.

Янжуур тамхины гадна байдал: шүүлтүүртэй янжуур тамхины шүүлтүүр нь байхгүй байх, тамхины цаас цоорсон байх, шарласан байх, тамхины уртын дагуу наалт салсан байх, тамхи өөр хольцтой байх (тамхины цаасны уранхай тасархайгаас өөр);

А.4. Дунд гэмтэл, согогт тооцох үзүүлэлт

Хайрцагны гаднах байдал: хайрцагны аль нэг талын наалт хэсэгчлэн салсан байх; онгойлгогч тууз байхгүй байх; шошгон дээрх барааны тэмдэг, бичиг хөдөлсөн эсвэл үл ойлгогдохоор байх.

Янжуур тамхины гадна байдал: гадна талын цаасны үзүүр цоорч сэмэрсэн байх; янжуур тамхин дээр тухайн оноосон нэр байхгүй байх; машины тосны толбо 3 мм-ээс хэтрэхгүй байх; тамхин дотор тамхины цаасны уранхай тасархай байх; янжуур тамхины сүүл хэсэг 3 мм-ээс илүүгүй урагдсан байх.

А.5 Бага согогт тооцох үзүүлэлт

Хайрцагны гаднах байдал: хайрцагны хэлбэрийн үл мэдэг гажилт, онгойлгогч туузны үзүүрүүд нь бага зэрэг зөрсөн байх, хамгаалалтын цаас үрчийж гэмтсэн байх;

Янжуур тамхины гаднах байдал: оноосон нэр ойлгогдохгүй байх, янжуур тамхи урагдсан байх, тамхины цаас үрчлээстэй байх, тамхины үзүүрийн наалтын задралт 3 мм- ээс хэтрэхгүй байх;

А.6 А.1-ын дагуу цуглуулсан хайрцгийн үнэлсэн 3 төрлөөс янжуур тамхийг нэг дээж болгож согогийн дагуу дахин 3 хэсэгт ангилна. Хэрэв хайрцаг болон янжуур тамхинд нэг зэрэг хэд хэдэн төрлийн гэмтэл согог илэрсэн тохиолдолд хамгийн их согогтойгоор нь тооцно. Хэрэв хайрцаг юмуу янжуур тамхинд нэг төрлийн гэмтэл давтагдвал нэг төрлийн гэмтэл гэж үзнэ.

MNS 5024:2013

A.7 Их гэмтэл согогтойг 10 оноогоор, дунд гэмтэл согогтойг 3 оноогоор, бага согогтойг 0,3 оноогоор тус тус дүгнэх ба энэ аргаар тогтоогдох гэмтэл согогийн оноо 120 - иос хэтрэхгүй байна. Төрөл болгоноос гэмтэлтэй хайрцаг, янжуур тамхины тоог гаргана. Янжуур тамхины болон хайрцагны гадна байдлын ерөнхий дүнг дараах томъёогоор гаргана.


$$O = 10A + 3B + 0,3B$$

үүнд : А - их гэмтэл согогтой янжуур тамхи болон хайрцагны тоо;
Б - дунд гэмтэл согогтой янжуур тамхи болон хайрцагны тоо;
В - бага согогтой янжуур тамхи болон хайрцагны тоо.

**“В” ХАВСРАЛТ
(норматив)**

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗУРАГТ АНХААРУУЛГЫН ЗАГВАР, ТАЙЛБАР

Зурагт анхааруулга №1



Зурагт анхааруулга №2



MNS 5024:2013

Зурагт анхааруулга № 3



Зурагт анхааруулга №4



Зурагт анхааруулга №5



Зурагт анхааруулга № 6




**“С” ХАВСРАЛТ
(норматив)**

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗУРАГТ АНХААРУУЛГЫГ ХАЙРЦАГ ДЭЭР
БАЙРЛУУЛАХ ЗАГВАР**



**“D” ХАВСРАЛТ
(норматив)**

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗУРАГТ АНХААРУУЛГЫГ БООДОЛ ДЭЭР
БАЙРЛУУЛАХ ЗАГВАР**



**“E” ХАВСРАЛТ
(мэдээллийн)**

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗУРАГТ АНХААРУУЛГЫГ АВДАР ДЭЭР
БАЙРЛУУЛАХ ЗАГВАР

